**НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

# 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

/2023.12.25/

**УЛААНБААТАР ХОТ**

**АГУУЛГА**


| | |
|---|---|
| **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**<br>Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэмжээний хэрэгжилт<br>Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт | |
| **ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**<br>Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт<br>Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл<br>МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт<br>Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилт<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт<br>Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт<br>Нийслэлийн Засаг даргаас зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил | |
| **ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**<br>Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт<br>Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа<br>Архив, албан хэрэг хөтлөлт<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт<br>Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа<br>Төсөв, санхүү, орлого бүрдүүлэлт | |
| **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**<br>Үйл ажиллагааны ил тод байдал<br>Хүний нөөцийн ил тод байдал | |
| **ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ**<br>Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай<br>Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний талаар<br>Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар | |

## 1.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр", Агаарын тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар:

- ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 зорилт бүхий 2 арга хэмжээний 2 заалтын хэрэгжилт
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 зорилт 13 арга хэмжээний биелэлт
- Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 14 зорилт 12 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн 2023 жилийн эцсийн байдлаар гарган Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох газарт хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.

Байгууллагын бодлогын зорилтуудын хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд тухай бүр тайлагнаж ажиллав.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

а). Байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолын 1 шийдвэрийн 1 заалтыг хяналтад авч хэрэгжилтийн хувийг тооцон гарган Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн танилцуулгын хамт НЗДТГ-ХШҮХ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж хувь 100%-тай байна.

Дээд газраас ирсэн 8 хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 12 заалтыг хяналтад авч хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тайлан мэдээг холбогдох газарт хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийг хяналтад авч биелэлтийг хагас жилийн байдлаар болон жилийн эцсийн байдлаар гаргаж, тайланг хугацаанд нь хүргэж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 01-04, 01-06, 01-06а, 02-03, 02-04 дугаар хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг гарган цаасаар болон http://monitoring.ub.gov.mn цахим хуудсанд оруулж тайлагнасан.

б) Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ:

2023 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн удирдах ажилтнуудын ажилтнуудын 30 удаагийн шуурхай зөвлөгөөнөөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар

хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж /https://old.ulaanbaatar.mn/,
ERP.Ulaanbaatar.mn Хяналт шинжилгээ үнэлгээ системд тухай бүр хугацаанд нь тайлагнасан.

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2023 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.
- Авилгатай тэмцэх газрын төлөвлөгөөний биелэлт,
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хорооны хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гаргасан.
- “Орон нутаг дахь хүний төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”-ын дагуу Хүний эрхийн төлөв байдлын тайланг хагас жилийн байдлаар болон жилийн эцсийн байдлаар гарган, холбогдох газарт хүргэж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтцийг өөрчилж 4 хэлтэстэй болгож, орон тооны хязгаарыг 48 хүртэл байхаар тогтоосон. Уг захирамжаар өөрчлөгдсөнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/164 дүгээр захирамжаар “Байгууллагын дүрэм"-ийг шинэчлэн батлуулсан. Төрийн захиргааны 31, төрийн үйлчилгээний 17, нийт 48 хүний орон тоотой батлагдсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар тус газар нь төрийн захиргааны 21, төрийн үйлчилгээний 13 албан хаагч ажиллаж байна.

Төрийн хяналт, шалгалтын зарим чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нар шилжин ирж байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан шинэ чиг үүргийн албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авахаар Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ТАЗ-ийн 2023 оны 198, 199 дүгээр тогтоолуудаар шинэ бүтэц, орон тоондоо тохируулан шинээр 5, шинэчлэн 5 буюу нийт 10 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрлийг авч ажиллаад байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

### 3.1. “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журам”-ыг баталж, хэрэгжүүлнэ.

“Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журам”-ыг шинэчлэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийг батлуулж Налайх дүүргийн гэр хорооллын 8 хорооны 7691 өрхийг агаарын чанарыг сайжруулах бүсэд хамруулан хяналт тавин хэрэгжилтийг

ханган ажилласан. Налайх дүүргийн 33 хяналтын ажилтан орчны бохирдлыг бууруулахад идэвхтэй оролцож, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэн хяналт тавин хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн 2023 оны Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журамыг батлуулахаар төслийг бэлтгэн НЗДТГ-аас санал авч байна.


БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН
ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/424, А/1553 Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, 2022 оны 223 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг 1 дүгээр, тухайн бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэ тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд)-т, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын алба (Б.Алтанзул), Нийслэлийн Засаг даргын нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч (З.Төмөртөмөө)-д тус тус үүрэг болгосугай.
3. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хэвлэл мэдээллийн алба /Ц.Үүрцайх/, Нийслэлийн сургалт, судалгаа олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т болон дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.
4. Энэ хамтарсан тушаал, захирамж гарсантай холбогдуулан "Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоох тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/322, А/780 дугаар хамтарсан тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Б.БАТ-ЭРДЭНЭ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР


Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424, А/1553 дугаар хамтарсан тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС

/2022-2023/

| Дүүрэг | 1 дүгээр бүс /Хороо/ | 2 дугаар бүс /Хороо/ | 3 дугаар бүс /Хороо/ | 4 дүгээр бүс /Хороо/ |
|---|---|---|---|---|
| Сонгинохайрхан | 1, 2, 3, 4,19, 20, 21, 22, 24, 25, 26, 27, 32, 33, 34, 35, 36, 39, 40, 41, 42, 43 | 5, 6, 7, 8, 9, 10, 11, 23, 28, 30, 31 | - | 12, 13, 14, 15, 16, 17, 18, 29, 37, 38 |
| Баянзүрх | 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 17, 19, 20 22, 23, 24, 28, 30, 32, 33, 34, 35, 37, 38, 39, 41, 42 | 2, 21, 25, 27, 29 | - | 1, 3, 4, 5, 6, 7, 15, 18, 26, 31, 36, 40, 43 |
| Чингэлтэй | 17, 18, 19, 23, 24 | 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 20, 21, 22 | - | 1, 2, 3, 4, 5, 6 |
| Сүхбаатар | 9, 17, 18, 19, 20 | 11, 12, 13, 14, 15, 16 | - | 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10 |
| Баянгол | 9, 10, 11, 20, 21, 22, 23, 29 | - | 16 | 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 12, 13, 14, 15 17, 18, 19, 24, 25, 26, 27, 28, 30, 31, 32, 33, 34 |
| Хан-Уул | 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 | - | - | 1, 2, 3, 15, 17, 18, 19, 20, 24, 25 |
| Налайх | 1, 3, 4, 5, 6, 7, 8 | 2 | - | - |
| НИЙТ ХОРОО | 87 | 36 | 1 | 73 |
| | 197 | | | |
| Тайлбар | Түүхий нүүрсийг үе шаттай хориглоно. | Цахилгаан болон бусад эх үүсвэрээр үе шаттайгаар холбоно. | | Бүх төрлийн хатуу түлш хэрэглэхийг хориглоно. |


Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424, А/1553 дугаар хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД
МӨРДӨХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Агаарын тухай хуулийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор шинэчлэн тогтоосон нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс /цаашид "бүс" гэх/-д мөрдөх дэглэм (стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэх талаар хүлээсэн үүрэг, хариуцлагыг тодорхойлох), түүхий нүүрс хэрэглэхийг хориглох, түүхий нүүрс тээвэрлэх, ашиглах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, журмын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Агаарын чанарыг сайжруулах бүсэд дараах стандартын шаардлага хангасан түлш, зуух, эрчим хүчний эх үүсвэр хэрэглэнэ. Үүнд:
1.2.1."Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага" MNS5216:2016 стандартыг хангасан халаалтын зуух;
1.2.2."4.2МВт хүчин чадалтай ус халаах зуухны техникийн шаардлага" MNS5043:2016 стандартыг хангасан халаалтын зуух;
1.2.3."Сайжруулсан хатуу түлшний техникийн шаардлага" MNS5679:2019 стандартыг хангасан сайжруулсан түлш;
1.2.4."Шингэрүүлсэн нефтийн хий, ахуйн хэрэглээний түлшний техникийн шаардлага" MNS 5083:2001 стандартыг хангасан түлш;
1.2.5.Нар, салхи, газрын гүний дулааныг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх сэргээгдэх эрчим хүчний үүсвэр;
1.2.6.Стандартын шаардлага хангасан, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж;
1.2.7."Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал" MNS 6457:2014 стандартын 4.6-д заасан баяжуулсан нүүрс.
1.2.8.Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан нүхэн жорлон, угаадасны нүх.

**Хоёр. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**
2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 1.2-т заасныаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
2.1.1. сайжруулсан шахмал түлш худалдан авахдаа түлш үйлдвэрлэгч байгууллагаас олгосон хяналтын картыг ашиглах;
2.1.2. мэргэжлийн хяналтын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
2.1.3. сайжруулсан шахмал түлшний шаталтаас үүссэн үнсийг ахуйн хог хаягдлаас тусгайлан ангилж, битүүмжлэлтэй саванд хадгалж, зөөвөрлүүлэх;

**Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшийг түгээлт тээвэрлэх, нөөцлөх, борлуулах үйл ажиллагааг дэмжиж, хяналт тавина.**

***<u>Сайжруулсан түлшний түгээлт, тээвэрлэлтэд дэмжлэг үзүүлж хяналт тавих ажлын хүрээнд;</u>***

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай" А/168 дугаар захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллахыг НАОБТГ-т даалгасан. Энэ ажлын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2023-2024 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 31 багц ажлыг www.tender.gov.mn-д зарлаж 31 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. 2023 онд 31 тээврийн компани нь Баруун болон Зүүн бүсийн үйлдвэрээс борлуулалтын цэг, агуулах, агуулахаас борлуулалтын цэг хүртэл нийт 583,439.025 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн ажиллаж байна.

НАОБТГ нь сайжруулсан шахмал түлш тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад тээвэрлэсэн түлшний тонн хэмжээ болон гүйцэтгэлийг хянан 2023 онд 13,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон хяналт тавин ажиллаж байна.

*Хүснэгт 1.*

| Ачилтын тайлан : | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Дүүрэг** | **Өдөр 09:00-23:59 хооронд** | | **Шөнө 00:00-09:00 хооронд** | | **Нийт кг** | |
| | | **Тоо** | **Жин кг** | **Тоо** | **Жин кг** | **Тоо** | **Жин кг** |
| 1 | **Сонгинохайрхан** | 24,678 | 165,264,425 | 5006 | 36,125,750 | 29,684 | 201,390,175 |
| 2 | **Хан-Уул** | 6,784 | 49,967,650 | 1522 | 12,081,350 | 8,306 | 62,049,000 |
| 3 | **Чингэлтэй** | 8,903 | 61,895,900 | 1718 | 13,985,000 | 10,621 | 75,880,900 |
| 4 | **Баянзүрх** | 14,788 | 105,999,500 | 3481 | 27,155,000 | 18,269 | 133,154,500 |
| 5 | **Сүхбаатар** | 5,834 | 39,161,000 | 1275 | 9,480,000 | 7,109 | 48,641,000 |
| 6 | **Баянгол** | 3,501 | 24,104,650 | 926 | 6,370,000 | 4,427 | 30,474,650 |
| 7 | **Налайх** | 4,062 | 25,833,800 | 833 | 6,015,000 | 4,895 | 31,848,800 |

| Нийт | 68,550 | 472,226,925 | 14761 | 111,212,100 | 83,311 | 583,439,025 |
|---|---|---|---|---|---|---|

**Сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд;**

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай” А/167 дугаар захирамжаар 2023-2024 оны халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 120 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг НАОБТГ-т үүрэг болгосон. Энэ ажлын хүрээнд НАОБТГ-ын даргын тушаалаар агуулах түрээслэх, сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, шаардлага хангаж түлш нөөцлөх боломжтой 53 агуулахыг Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар болон “Таван толгой түлш” ХХК-тай хамтран сонгон шалгаруулж ажилласан.

2023 онд шаардлага хангаж түлш нөөцлөх боломжтой 53 агуулах, Нийслэлийн өмчийн 4 агуулахад нийт 120,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай “Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ”-г байгуулан хяналт тавин 4.6 тэрбум төгрөгийн агуулахын түрээсийн санхүүжилтийг олгон ажиллаж байна





*Хүснэгт 2.*

| № | | Дүүрэг | Агуулахын тоо | Нийт нөөц |
|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны түлшний нөөцийн мэдээг | Баянзүрх | 9 | 19,565 |
| 2 | | Сонгинохайрхан | 26 | 32,092.5 |
| 3 | | Чингэлтэй | 1 | 11,877.5 |
| 4 | | Сүхбаатар | 1 | 7,690 |
| 5 | | Баянгол | 1 | 8,560 |
| 6 | | Хан-Уул | 10 | 17,974.6 |
| 7 | | Налайх | 9 | 7,660 |
| 8 | | “Таван толгой түлш” ХХК үйлдвэрт | - | 12,814 |
| **Нийт** | | | **57** | **120,000** |

**Сайжруулсан түлшний борлуулалтын цэгийн татан авалтын ажлын хүрээнд;**

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/138 дугаар захирамж батлагдаж сайжруулсан шахмал түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх,

түлшний эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор нэг тонн сайжруулсан шахмал түлшний борлуулалт тутамд 15,000 төгрөгийн урамшуулал олгохоор тусгагдсан.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь “Таван толгой түлш” ХХК-тай 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Сайжруулсан шахмал түлшний борлуулалтад урамшуулал олгох гэрээ”-г байгуулсан.

2023-2024 оны халаалтын улиралд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш борлуулах 650 борлуулалтын цэгийг нээн ажиллуулахаар төлөвлөсөн. Энэ ажлын хүрээнд “Таван толгой түлш” ХХК нь 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 650 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгийг нээн ажиллуулж, гэр хорооллын 203,683 айл өрхийг 340,496 тонн сайжруулсан шахмал түлшээр хангаж, борлуулалтын урамшууллын зардалд нийт 5,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

*Хүснэгт 3.*

| Баянгол | Баянзүрх | Сонгинохайрхан | Хан-Уул | Сүхбаатар | Чингэлтэй | Нд |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | 160 | 222 | 52 | 63 | 93 | 30 |
| **Цэгийн тоо** | **650** | | | | | |






**1 тн түлш 150,000₮** **1 шуудай түлш 3,750**

**Сайжруулсан түлшний баруун, зүүн бүсийн үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд;**

Сайжруулсан шахмал түлшний баруун болон зүүн бүсийн үйлдвэр нь хоногт дунджаар 1,800-2,200 тонн сайжруулсан шахмал түлшийг нийслэлийн гэр хорооллын айл өрхийн хэрэглээнд зориулан тасралтгүй үйлдвэрлэж байна.

*Хүснэгт 4.*

| Үйлдвэр | Сайжруулсан түлш үйлдвэрийн шугам (өдөрт) | Хоногт үйлдвэрлэж буй түлшний хэмжээ, тн |
|---|---|---|
| Зүүн үйлдвэр | 4 | 800 |
| Баруун үйлдвэр | 10 | 1,400 |
| Нийт | 14 | 2,200 |






**Сайжруулсан шахмал түлшний агуулах барьж, үйл ажиллагааг жигдрүүлэх ажлын хүрээнд;**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/1026 дугаар захирамж батлагдан сайжруулсан шахмал түлшний агуулах барих, худалдан авах төсөл арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу агуулах худалдан авах ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулсан боловч гомдол гарч шүүхийн шатанд хянагдан дахин санхүүжилт авах хүсэлтийг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд хүргүүлсэн боловч Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 396 дугаар тогтоолоор “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-г татан буулгах болсонтой холбогдуулан тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.

*Хүснэгт-5*

| Нэр | Одоо мөрдөгдөж байгаа тариф /төг/ |
|---|---|
| Үйлдвэрээс агуулах | 28,050+7550 |
| Үйлдвэрээс борлуулалтын цэг | 28,050+7550 |

**Сайжруулсан түлшний үйлдвэр, агуулах, хангамжийн бааз хариуцан ажиллах хяналт зохицуулалтын ажилтнуудын өдөр тутмын хийж хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах;**

Тус ажлын хүрээнд “Таван толгой түлш” ХХК-ийн Баруун болон зүүн бүсийн үйлдвэрийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний агуулах, хангамжийн баазад нөөцөлсөн түлшинд тогтмол хяналт ажиллах зорилгоор хяналт зохицуулалтын ажилтнуудын хуваарийг сар бүр гарган батлуулж, өдөр тутмын үйл ажиллагааг хянаж, мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажилласан.

“Таван толгой түлш” ХХК-аас илгээсэн мэдээтэй тулган нягталж, үнэн зөв эсэхийг нягталж баталгаажуулж мэдээллийн сан үүсгэж ажилласан.

Мөн хяналт зохицуулалтын ажилтнуудаас улирал, хагас ба бүтэн жилийн тайлан мэдээ авч нэгтгэн удирдлагад тайлагнасан.



БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТШАГАЙ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН АЖИЛТНУУДЫН ХУВААРЬ

2023.10.01 Улаанбаатар хот

| № | Овог Нэр | Үйлдвэр |
|---|---|---|
| 1 | Д.Батсурэн | Зүүн |
| 2 | Б.Отгонбаяр | Зүүн |
| 3 | Б.Бат-Орших | Зүүн |
| 4 | Б.Оюун-Эрдэнэ | Зүүн |
| 5 | Б.Болортуяа | Баруун |
| 6 | Э.Сарантуяа | Баруун |
| 7 | Р.Болд-Эрдэнэ | Баруун |

Тайлбар: ■ - Үйлдвэрт гарах өдөр
□ - Агуулахаар явах өдөр

ТАНИЛЦСАН: БХХ-ИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН
ХЯНАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БАТЦЭЦЭГ
БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН АЖИЛТАН Г.НОМИН



Дотоод албан хэрэгцээнд

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР
САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШНИЙ БОРЛУУЛАЛТ, НӨӨЦ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 11 дүгээр сарын 29 Улаанбаатар хот

**Нэг. Тухайн өдрийн үйлдвэрийн тоон мэдээ (Өдөр бүр)**

2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 02-ны өдрийн 12 цаг 00 хүртэлх байдлаар сайжруулсан шахмал түлшний тоон мэдээлэл :

| Хаяг | Үйлдвэрийн тоо | Ажиллаж байгаа шугамны тоо | Үйлдвэрлэсэн шахмал түлш /тн/ |
|---|---|---|---|
| Баруун үйлдвэр | I | - | - |
| | II | 1 | 75 |
| | III | 2 | 367 |
| | VI | 2 | 205 |
| Зүүн үйлдвэр | I | 1 | 110 |
| | II | 3 | 690 |
| НИЙТ ДҮН | | 9 | 1447 |

**Хоёр. Тухайн өдрийн борлуулалтын цэгийн захилга, нөөц (Өдөр бүр)**

2023-2024оны халаалтын улиралд агаарын чанарыг сайжруулах бүсийн 197 хороонд 650 борлуулалтын цэг нээн ажиллаж байна. Таван толгой түлш ХХК-ийн **2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдрийн 12 цаг 00** минутын байдлаар Нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 631 борлуулалтын цэгт 2565 тонн сайжруулсан шахмал түлшний захиалга авсан байна.

| Дүүрэг | Цэгийн тоо | Түлшний захиалга, тн | Шахмал түлшний нөөц, тн |
|---|---|---|---|
| Баянгол | 28 | 75 | 6,145 |
| Баянзүрх | 151 | 610 | 17,84 |



Дотоод албан хэрэгцээнд

| № | ШНТ | Хяналт шалгалт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрөлтэй нэвтрүүлсэн нүүрс, тонн | Зөвшөөрөлтэй дамжин өнгөрүүлсэн түүхий нүүрс, тонн | Зөвшөөрөлгүй нэвтрүүлэхийг завдсан түүхий нүүрсний зөрчил, тонн | Зөвшөөрөлгүй сайжруулсан шахмал түлшний зөрчил, тонн | Торгууль, төгрөг |
| 1 | Эмээлт | 198.9 | 4359.3 | - | 0.25 | 100,000 |
| 2 | Баруун туруун | 253.74 | 837.17 | - | 15.5 | 400,000 |
| 3 | Гүнт | 0 | 26.2 | - | - | - |
| 4 | Өлзийт | 3009.5 | 9411.31 | - | - | - |
| 5 | Таван толгой | 731.4 | - | - | 1 | 100,000 |
| 6 | 4-р зөрлөг | 2875.78 | 4221.45 | - | 13.8 | 500,000 |
| 7 | Городок | 5279.8 | 4820 | - | 1.8 | 200,000 |
| | Нийт | 12349.12 | 23475.43 | - | 32.35 | 1.300.000 |

**Дөрөв. Гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын ханан пийшин болон зуухны гэмтлийн тоон мэдээлэл (14 хоног тутамд 1 удаа өссөн дүнгээр)**

Таван толгой түлш ХХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвөөс 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минутын байдлаар Нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд ханан пийшин болон зуухны гэмтэлтэй айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, утаарын хийн мэдрэгч төхөөрөмжгүй өрхийн тоо 34759 байна.

| Дүүрэг | Суугчны төрөл | | | Ханан пийшин гэмтэлтэй | | | Зуухны гэмтэлтэй | | | | Утаарын хийн мэдрэгч төхөөрөмжгүй өрхийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байшин | Гэр | Нийтийн байр | Сайн | Муу | Дунд | Битүүмж алдагдсан | Дотор логоо харагсан | Ширэм харагсан | Үнсний шүүр харагсан | |
| БГД | 4538 | 3718 | 129 | 1417 | 660 | 491 | 1856 | 1017 | 412 | 591 | 1150 |

**Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос**

**урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлэх;**

Агаарын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Засгийн газрын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62, 223 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1025 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр газрын даргын баталсан  удирдамж болон хуваарийн дагуу  2023 оны 02 дугаар сарын 08 - 20-ны өдрүүдэд 7 дүүргийн 1000 гаруй иргэн, хэсгийн ахлагч, зохион байгуулагч нарт угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах сургалтыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, “Таван толгой түлш” ХХК-ийн “Хэрэглэгчид үйлчлэх төв”-тэй хамтран зохион байгуулсан. Мөн тус захирамжийн хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газар-тай хамтран “ Угаарын хийн хордлогоос урьчилан сэргийлэх зуухны стандартыг хангах”, “Угаарын хийн хордлогын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Агаарын чанарын төлөв байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ”, “ Зөв галлагаа” зэрэг сургалт, мэдээллийг Нийслэлийн Засаг захиргааны 2 дугаар байранд гэр хороололд байршилтай 52  сургуулийн 50 нийгмийн ажилтанг хамруулан зохион байгуулсан.






Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/1030 “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээнийн тухай” захирамжийн дагуу угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөв галлагаа сэдэвт сургалтыг нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах 7 дүүргийн хэсгийн ахлагч, зохион байгуулагч, холбогдох төрийн албан хаагчид, иргэд олон нийтийн дунд зохион байгуулсан. Уг сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрүүдийн хооронд зохион байгуулж нийт 197 хорооны 2500 гаруй төрийн албан хаагч, иргэд олон нийт, Их дээд сургуулийн багш, оюутнуудыг хамруулсан.









“Бидний оролцоо-Цэвэр орчин” аяны хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсийн 5 дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрүүдийн хооронд “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх эрсдэлээс хамгаалах-Зөв галлагаа” өдөрлөгийг зохион байгуулан ажилласан.











Тус байгууллагатай хамтран ажилладаг 4 телевиз, 10 сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 6 төрлийн брошур, 5 төрлийн видео шторк, гэр хорооллын бүсэд байрлах ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд хичээл эхлэхийн өмнө 10 минутын угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийн талаар мэдээлэл хийж, гэр хорооллын айл өрхүүдийн зуух, пийшингийн битүүмжлэлийн талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.









**Авто замын хөдөлгөөнд оролцож буй нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээний хүрээнд;**

"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ, "Тээврийн Цагдаагийн алба"-тай хамтран 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр болон 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн 32-ын тойргийн нутаг дэвсгэр, Чингэлтэй дүүргийн 39 дүгээр сургууль орчмоор, Баянгол дүүргийн 3,4 хороолол, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцож буй 93 автомашинд, тээврийн хэрэгслээс ялгарах хаягдал утаан дахь хорт бодис зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд хяналт шалгалт, хэмжилт хийн ажилласан. Уг хэмжилтээр дизель түлш ашигладаг 62, автобензин ашигладаг 31 тээврийн хэрэгсэл байсан бөгөөд нийт автомашины 51,6% буюу 50 тээврийн хэрэгсэл хаягдал утааны агууламж өндөр ялгаруулж байна.





**Уурын болон 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч, дулаан, цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр;**

Нийслэлийн Засаг даргын А/805 захирамж, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан удирдамжийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд магадлан итгэмжлэх, хяналт шалгалт хийгдлээ. Энэ халаалтын улиралд буюу 2022-2023 онд 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг ААНБ-ын магадлан итгэмжлэх хяналт шалгалтын дүнгээр Улаанбаатар хотын төвийн 9 дүүрэгт 208 байршлын 353 халаалтын зуух бүртгэгдэж, шалгагдав. Өмнөх онтой харьцуулахад 13,9%-иар буурч, төвлөрсөн дулаан, хий болон бусад дэвшилтэт технологид шилжсэн байна.






Мөн уурын болон 100 кВт-аас дээш хүчин чадалтай, агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх ажлын удирдамжийн төсөл боловсруулан Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулахаар ажиллаж байна.

**Гэр, байр, орон сууцны доторх агаарын бохирдлыг бууруулах, арилгахад чиглэсэн зөвлөмж гаргаж, олон нийтэд сурталчилах;**

Гэр хорооллын айл өрхийн орон байрны дулаалга, дулаан алдагдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргасан. Мөн байгууллагын албан ёсны https://aprd.ub.gov.mn/ цахим хуудсаар дамжуулан дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, байшин дулаалга зэрэг 6 төрлийн брошурыг иргэд олон нийтэд хүргэн ажилласан.

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу “Угаарын хийн хордлогын нөхцөл байдал”-ын эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр мэргэжлийн 21 байгууллагыг 32 хүний бүрэлдэхүүнтэйгээр Эрүүл мэндийн яамны хурлын их танхимд эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.


НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХОР СУДЛАЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА

УГААРЫН ХИЙН ХОРДЛОГЫН ҮЙЛ ЯВДАЛД ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 04



Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Орчны бохирдол үүссэн үеийн эрсдэлийн үнэлгээний хийх ажлын хэсгийн хурал 2023 оны 10 дугаар сарын 17-ны

өдөр тус яамны хурлын танхимд зохион байгуулж эрсдлийн үнэлгээг хийн ажилласан.

**Агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн сanг шинэчлэн бүрдүүлэх ажлын хүрээнд;**

Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамжийг тус тус үндэслэн агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг жил бүр нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулдаг.

Тус ажлын хүрээнд Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл тооллогыг батлагдсан маягтын дагуу бөглөж, www.envpol.mne.gov.mn цахим системд бүртгэлжүүлэхээр ажиллаж байна. 2022-2023 оны байдлаар 3-15квт хүчин чадалтай ахуйн хэрэглээний **162,552** зуух, 16-100 кВт хүчин чадалтай **3,751** зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай **353** усан халаалтын зуух, Дулааны цахилгаан 6 станцын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай **41** зуух, Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр нийт **655656** тээврийн хэрэгсэл тус тус тоологдож, мэдээллийн санг шинэчлэн ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх тухай” А/1313 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт ажлын хэсэг байгуулахаар удирдамжийн төсөл боловсруулан ажиллаж байна.





**“Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэд технологид шилжүүлэх тухай” 123 дугаар тушаалын хүрээнд;**

Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Шадар сайдын 2020 оны “Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай” 123 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Халаалтын зуухны үзлэг, шалгалт зохион байгуулах тухай” А/09 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын хийх ажлыг 5 ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 01 дүгээр сарын 27-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсан. 2022-2023 онд 100 кВт-аас дээш хүчин

чадалтай зуух ашигладаг ААНБ-ын магадлан итгэмжлэх хяналт шалгалтын дүнгээр Улаанбаатар хотын төвийн 9 дүүрэгт 208 байршлын 353 халаалтын зуух бүртгэгдэж, шалгагдав. Өмнөх онтой харьцуулахад 13,9%-иар буурч, төвлөрсөн дулаан, хий болон бусад дэвшилтэт технологид нийт 57 зуух шилжсэн байна.

***Агаарын чанарын хяналт, шинжилгээний чадавхыг сайжруулах сайжруулж PM10, PM2.5 тоосонцрын агууламжийг багасгана.***

Агаарын чанарын суурин харуулуудын мэдээг 7 хоног, сараар боловсруулан гарган Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлэн ажиллаж байна.

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлон ажилладаг.

2023 оны хүйтний улирлын 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 3 мкг/м-ээр буюу 5%-иар их, PM10 тоосонцор 10 мкг/м3-ээр буюу 10%-иар бага байсан.

*Хүснэгт 6*

| Бохирдуулах бодисын нэр | Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 | Дундаж агууламж, мкг/м$^3$ | |
|---|---|---|---|
| | Хүлцэх агууламж, мкг/м$^3$ | 2022 оны 11 дүгээр сар | 2023 оны 11 дүгээр сар |
| PM2.5 тоосонцор | 50 | 55 | 58↔ |
| PM10 тоосонцор | 100 | 97 | 87↓ |
| Азотын давхар исэл, $NO_2$ | 50 | 51 | 50↔ |
| Хүхэрлэг хий, $SO_2$ | 50 | 85 | 64↓ |




Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор 4 төрлийн хэмжилтийн хүсэлтийг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аар хүлээн авч эхэллээ. Үүнд:

- Авто тээврийн хэрэгслийн утааны хийн хэмжилт
- Орчны хөдөлгөөнт хэмжилт
- Усан халаалтын зуухнуудад хаягдал утааны хэмжилт
- Хүн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн сайжруулсан хатуу түлшний хаягдал утааны хэмжилт орж байна.

Энэхүү системийн давуу тал нь иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад төрийн үйлчилгээг харьяалал харгалзахгүйгээр нэг дороос түргэн шуурхай авах болсноороо онцлог юм.

1.Байгууллагын 2023 оны жилийн эцсийн байдлаар нэг суурин харуул дээр дунджаар 60 удаа очиж засвар үйлчилгээ, стандарт хийн тохируулга, хийж ажилласан. Суурин харуул тус бүрээр авч үзэхэд Баянхошуу суурин харуул дээр 59, Толгойт суурин харуул дээр 60, Нисэх суурин харуул дээр 58, Амгалан суурин харуул дээр 61, МҮОНРТ суурин харуул дээр 63, Дамбадаржаа суурин харуул дээр 57 удаа тус тус очиж ажилласан. Тус харуулуудаар очиж ажиллахдаа хэмжилтийн хэвийн үйл ажиллагааг хангах, багажуудын тоосны шүүлтүүр солих, шугам хоолойн цэвэрлэгээ хийх, хэмжилт тасарсан тохиолдолд дахин ачаалуулах зэргээр ажилласан.

2.Толгойт суурин харуул болон МҮОНРТ-ийн суурин харуулын азотын ислүүд хэмжих төхөөрөмж хэмжилтийн горим доголдож хэвийн үйл ажиллагаа тасалдсан тул Жайка төслийн экспертүүдийн тусламжтай тус багажийг үйлдвэрлэгч компанитай холбогдож цахим уулзалт хийж заавар зөвлөгөө авч засвар үйлчилгээ хийж хэмжилтийг хэвийн болгож төхөөрөмжийн тасралтгүй хэмжих үйл ажиллагааг хангаж ажилласан.




3.Орчны агаарын чанар хэмжих  суурин харуулуудын хэвийн үйл ажиллагааг хангах болон хэмжилтийн багаж тоног төхөөрөмжүүдийн мэдээллийн баталгаажилтыг хангах ажлын хүрээнд сар бүр стандарт хийн тохиргоо хийж ажилласан.

4.Суурин харуулын өвлийн бэлтгэл ажил хангах, хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангуулах ажлын хүрээнд суурин харуулын сэлбэг хэрэгсэл худалдан авах тендер зарлах ажлын бэлтгэл ажил хангаж ажлын даалгавар боловсруулан батлуулж, үнэлгээний хороо байгуулж, худалдан авах ажиллагаа зохион байгуулж, шалгарсан “Интерсайнс” ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр НАОБТГ03-07 тоот гэрээ байгуулж 2023 оны 08 дугаар сарын 04-ний хүлээн авсан.

5. Дамбадаржаа суурин харуулын засвар үйлчилгээнд ашиглагдах сэлбэг хэрэгсэл худалдан авах ажлын даалгавар боловсруулан үйлдвэрлэгч компанитай НАОБТГ 03-05 тоот гэрээ байгуулан 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч тус харуул дээр сэлбэг хэрэгслийг сольж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

6.Суурин харуулын хэмжилтийн ажилласан нийт цаг 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс 2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар МҮОНРТ-91.4%, Нисэх-87.1%, Толгойт-90.5%, Амгалан-90.2%, Баянхошуу-75.9% байна. Суурин харуулуудын нийт дундаж хэмжилтийн цаг 88,1%-ийн гүйцэтгэлтэй байна. Суурин харуулуудын хэмжилт тасарсан шалтгаан хэмжилтийн багажийн насжилт өндөр, тог цахилгааны гэмтэл, цахилгааны ачаалалтай үед автомат унах, цахилгааны төлөвлөгөөт засвар үйлчилгээ зэрэг шалтгаанаас суурин харуулын мэдээ тасарсан байна.

*Хүснэгт-7*

| 2023/01/01-2023/11/30 хүртэл ажилласан цаг | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэмжилтийн төрөлүүд | МҮОНРТ | | Нисэх | | Толгойт | | Амгалан | | Баянхошуу | |
| | Хэмжих цаг | | Хэмжих цаг | | Хэмжих цаг | | Хэмжих цаг | | Хэмжих цаг | |
| | 8016 | Хувь | 8016 | Хувь | 8016 | Хувь | 8016 | Хувь | 8016 | Хувь |
| | Хэмжсэн цаг | | Хэмжсэн цаг | | Хэмжсэн цаг | | Хэмжсэн цаг | | Хэмжсэн цаг | |
| NOx | 7230.0 | 90.2 | 7535 | 94.0 | 6298.0 | 78.6 | 7673 | 95.7 | | |
| CO | 7555.0 | 94.2 | 7438 | 92.8 | 7279.0 | 90.8 | 7616.0 | 95.0 | | |
| SO2 | 7032.0 | 87.7 | 5227 | 65.2 | 7542.0 | 94.1 | 5284.0 | 65.9 | 4524.0 | 56.4 |
| PM10 | 7556.0 | 94.3 | 7471 | 93.2 | 7544.0 | 94.1 | 7664.0 | 95.6 | 7311.0 | 91.2 |
| PM2.5 | 7566.0 | 94.4 | 7471 | 93.2 | 7544.0 | 94.1 | 7664.0 | 95.6 | 6428.0 | 80.2 |
| O3 | 7030.0 | 87.7 | 7313 | 91.2 | 7333.0 | 91.5 | 7466.0 | 93.1 | | |
| Ажилласан цаг хувь | 7328.2 | 91.4 | 6984 | 87.1 | 7256.7 | 90.5 | 7227.8 | 90.2 | 6087.7 | 75.9 |
| Нийт | Суурин харуулуудын ажилласан цаг  80% | | | | | | | | | |

***Нийслэлийн агаарын чанарын суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж, хэмжилтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.***

Бүгд Найрамдах Солонгос улс болон Монгол Улсын Засгийн Газрын гэрээгээр агаарын чанар хэмжих суурин автомат харуулыг 2023 оны 09 дүгээр сард Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Арцатын 624, Байгаль орчны шинжилгээ, судалгааны төв УТҮГ-ын хашаанд байрлуулсан улсын нэгдсэн сүлжээнд холбож агаар.мн сайтаар иргэд олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.








***Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Агаарын чанарын стандарт"-ыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлнэ.***

"Агаарын чанарын стандарт"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Хотын стандартын газарт 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 1/468 тоот албан бичгээр ажлын хэсэгт орох албан хаагчдын нэрсийг хүргүүлэн ажилласан.

Тус ажлын хэсгийн хуралдаанаар Жайка Олон Улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн" хүрээнд боловсруулсан "Гэрийн зуухны хаягдал утааны хийн хэмжилтийн гарын авлагыг стандарт болгох тухай хэлэлцэж төслийг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний 1/628 тоот албан бичиг боловсруулан хүргүүлээд байна.

***Орчны бохирдлыг багасгаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.***

Агаарын тухай хууль тогтоомж, стандартын дагуу орчны агаарын чанарыг хэмжигч AQMS-9000 явуулын станцаар орчинд үзүүлж буй хорт нөлөөлөл, дотоод орчны бохирдлын хэмжилт хийх ажлын хүрээнд иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтийн дагуу стандартын шаардлага хангаж буй эсэхийг хэмжилт хийж тодорхойлж байна.

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 30 хэмжилт хийж үр дүнг (MNS4585:2016) стандарттай харьцуулсан. Тус харьцуулалтаар стандартын шаардлага хангаагүй 14, шаардлага хангасан 16 байсан. Нийслэлийн төсөвт нийт 1.280.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

*Хүснэгт-8*

| ***Орчны хэмжилтийн жагсаалт*** |
| --- |

| № | огноо | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Хаяг, байршил | Бохирдуулагч бодис /мкг/м3/-ээр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | $NO_x$ | $SO_2$ | CO | PM 2.5 |
| 1 | 2023/ 09/05 | “ Жи эс дорнын хөгжил” ХХК | MNS4585:2016 | | | 450 | 60000 | 50 |
| | | | Блокны үйлдвэр | СХД 32-р хороо | - | 122 | 204 | 38 |
| 2 | 2023/ 09/05 | “ Хос монгол” ХХК | MNS4585:2016 | | | 450 | 60000 | 50 |
| | | | Тоосгоны үйлдвэр | СХД 8-р хороо | - | 48 | 168 | 34 |
| 3 | 2023/ 09/05 | “Монгол тамхи со”ХХК | MNS4585:2016 | | | 450 | 60000 | 50 |
| | | | Хүнсний үйлдвэр | БГД 4-р хороо | - | 116 | 281 | 125 |
| 4 | 2023/ 06/26 | “Аянчин фоор сийзонз лордж”ХХК | MNS 4585:2016 | | | 450 | 60000 | 50 |
| | | | Амралтын газар | НД 6-р хороо | - | 71 | - | 28 |
| 5 | 2023/ 09/05 | “Бат Бэх Ремикон” ХХК | MNS 4585:2016 | | | 450 | 60000 | 50 |
| | | | Барилгын материалын үйлдвэр | БЗД 11-р хороо | - | 204 | 304 | 42 |
| 6 | 2023/ 09/05 | “Бат Бэх Ремикон” ХХК | MNS 4585:2016 | | | 450 | 60000 | 50 |
| | | | Барилгын материалын үйлдвэр | ХУД 21-р хороо | - | 281 | 497 | 62 |
| 7 | 2023/ 03/15 | “Багануур дүүрэг” | MNS 4585:2016 | | 50 | 50 | | 50 |
| | | | Дүүрэг | 5-р хороо | 16 | 33 | - | 121 |
| 8 | 2023/ 02/14 | “Багахангай дүүрэг” | MNS 4585:2016 | | 50 | 25 | | 50 |
| | | | Дүүрэг | 2-р хороо | 9 | 204 | 304 | 42 |
| 9 | 2023/ 02/14 | “Амин Хүнс” ХХК | MNS 4585:2016 | | 200 | 450 | 60000 | 50 |
| | | | Худалдааны төв | ЧД 11-р хороо | 67 | 46 | 238 | 37 |
| 10 | 2023/ 11/08 | “Тагын Эх” ХХК | MNS 4585:2016 | | 50 | 250 | 60000 | 50 |
| | | | Амралтын газар | СХД 34-р хороо | - | 172 | 1430 | 195 |
**Уурын болон 100 квт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух ашиглагч, дулаан, цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулна.**

БОАЖЯ-ны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 01/07 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд 52 объектын халаалтын зуух болон баримт бичигт хяналт шалгалт хийж 3 аж ахуйн нэгж, байгууллагыг 4000 нэгжтэй тэнцэх торгууль ногдуулж Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, мөн Хадат Вилла-1,3 СӨХ-д зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын баталсан А/05 тоот удирдамжийн дагуу Эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын уурын зуухнаас ялгарах түгээмэл тархацтай бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах, түүхий нүүрс хэрэглэх хэрэгжилтийг хангуулах хүрээнд УБЗАА, ЭЦА, ХИХУГ-тай хамтран ХУД болон ЧД-ийн нутаг дэвсгэрт дулаан түгээх үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч 50 аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын зууханд хяналт шалгалт, үзлэг хийж, үлдэгдэл түүхий нүүрсний судалгааг гаргаж, улсын байцаагчийн 2 заалттай албан шаардлагыг 3 аж ахуйн нэгжид хүргүүлж ажиллалаа.

БОАЖЯ-ны салбарын ерөнхий байцаагчийн баталсан 01/09 дугаартай удирдамжийн хүрээнд 75 аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын зуух болон баримт бичигт хяналтын хуудасны дагуу төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийхэд нийт 12 объект Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн заалтуудыг хангаж ажиллаагүй байсан тул Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу нийт 6000 нэгжтэй тэнцэх торгууль ногдуулж хялбаршуулсан журмаар шийдвэрлэн хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын

байцаагчийн албан даалгавар 12 аж ахуй нэгжид хүргүүлж, 2 заалттай улсын байцаагчийн 1 албан шаардлагыг 1 аж ахуйн нэгжид хүргүүлж ажиллалаа.




**Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгүүдэд түүхий нүүрсний хяналтыг тавих ажлыг үргэлжлүүлэх, байгаль орчны багц хуулиуд болон тэдгээртэй хамт гарсан журам, дүрмийн хэрэгжилтийг хангуулах.**

Эмээлт, Өлзийт, Гүнт, Городок, 5 толгой, Баруун туруун, 4-р зөрлөг 7 товчоонд Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын эргүүл хяналтын 23 албан хаагч 24 цагаар тогтмол үүрэг гүйцэтгэж байгаа ба хяналт шалгалтын тайлант хугацаанд: Мод 38 тээврийн хэрэгслээр 1167м3, Дамжин өнгөрсөн түүхий нүүрс 2064 тээврийн хэрэгслээр 65822тн,Зөвшөөрөлтэй нэвтэрсэн түүхий нүүрс 956 тээврийн хэрэгслээр 28076.5тн бүртгэгдэн нэвтэрсэн байна.




## 3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЖУУЛАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГАА

### Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилт

*Хүснэгт-19*

| Зорилт | № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин (тоо, хэмжээ, хувь) | Хүрсэн түвшин (хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ) | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлэр (мян.төг) | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 2 | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| 1.Хүний нөөцийг чадавх-жуулах | | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр | Дотоод сургалтын тоо | 5-аас доошгүй | 7 | 2.2 сая | МУ-ын ТАЗ-ийн 7:4:10 сургалт, Удирдлагын академийн мэргэшүүлэх ахлах болон дунд шатны багц сургалт, |
| | | | Албан хаагчдын хамрагдсан | 95 хувиас дээш | Давхардсан тоогоор 350 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1. | зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт | байдал | | 100% | | Нийслэлийн ЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвийн сургалт, "Алсын хараа-2050", Худалдан авах ажиллагааны А3 сургалт, бусад мэргэжлийн байгууллагын сургалтуудад хамрагдсан. |
| | | | Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал | 5 хувиас дээш | 8 хувь | - | JICA төслийн хүрээнд 3 удаагийн цахим сургалтад 5 албан хаагч хамрагдсан. |
| | 2. | Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх | 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | 95 хувиас дээш | 90 хувь | - | 3 болон түүнээс дээш жил ажилласан нийт 25 албан хаагч байна. |
| | **Хэсгийн дундаж: 100%** | | | | | | |
| 2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | 3. | Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Шагнал, урамшууллад хамрагдсан албан хаагчдын тоо | Гүйцэт-гэлээр | 34 албан хаагч<br><br>100% | Гүйцэтгэлийн Урамшуулал 24,799,244 төг | Албан хаагчдын Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэж уламшуулж ажилласан. Мөн Төрийн дээд болон Засаг даргын, ИТХ-ын шагналд нийт 32 албан хаагчийг уламжилж ажилласан. |
| | | | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах | Гүйцэт-гэлээр | **33** удаан жилийн нэмэгдэл,<br><br>**10** зэрэг дэвийн нэмэгдэл 100% | /ур чадварт 8,552,723 төг, зэрэг дэвийн нэмэгдэлд 15,563,111 төг, удаан жилийн нэмэгдэлд 12,453,052 төг буюу нийт 36,568,886 төгрөг/ | Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/511 дүгээр захирамжийн дагуу байгууллагын 8 төрийн жинхэнэ албан хаагчдад шинээр зэрэг дэв болон нэмэгдлийг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | олгосон.Мөн ТҮ-ний нийт 27 албан хаагчид 2023 оны Б/144 дүгээр тушаалаар ур чадварын нэмэгдэл 20-25 хувиар олгосон. |
| | | | Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх | Гүйцэт-гэлээр | Унаа-500 Хоол-9000 | 76,720,415 | Байгууллагын нийт албан хаагчдад унаа, хоолны нэмэгдлийг 2023 оны батлагдсан төсөвт багтаан олгож байна. |
| | | | Илүү цагийн ажлын цалин хөлсийг олгох | Гүйцэт-гэлээр | Бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдэд ажилласан албан хаагчдад нэмэгдэл олгож байна. | 7,307,844 | Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нийтээр амрах амралт, баяр ёслолын өдрүүдэд ажилласан албан хаагчдад газрын даргын тушаалаар нэмэгдэл хөлс олгож байна. |
| | 4. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал | Ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах | Гүйцэтгэл-ээр | 10 | 0,4 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус ажилтантай бөгөөд Авто тээврийн шалган нэвтрүүлэх 7 товчоонд 7 ш, Хяналт, зохицуулалтын 3 ажилтанд 3 ширхэг нийт 10 ширхэг хамгаалын хувцас, хэрэгслээр хангаж ажилласан. |
| | **Хэсгийн дундаж: 100%** | | | | | | |
| | 5. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | Жилд 1-ээс доошгүй удаа | 0 | 0 | Төсвөөс шалтгаалан хамрагдаагүй. |
| | | | Албан хаагчдын хамрагдалт | 100% | | | |
| | **Хэсгийн дундаж: 100%** | | | | | | |
| **Үнэлгээний дундаж хувь: 100%** | | | | | | | |

Албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор 2023 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, 1 дүгээр сард Газрын даргаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар танхимын сургалтад давхардсан тоогоор 350 дотоодын сургалт, семинарт оролцож, туршлага судалж, мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнийг дараах байдлаар авч үзвэл:

- МУ-ын ТАЗ-ийн 7:4:10 сургалт, Удирдлагын академийн мэргэшүүлэх ахлах болон дунд шатны багц сургалт, Нийслэлийн ЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвийн сургалт, “Алсын хараа-2050” Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 10 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.
- ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо байгууллагад нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургалтыг нийт албан хаагчдад 7 хоног бүрийн “Мягмар” гаригт тогтмол зохион байгуулан хамруулсан.
- Удирдлагын академийн мэргэшүүлэх багц 5 албан хаагчид суралцаж, 4 албан хаагч нь гэрчилгээ авсан.
- ТАЗ-өөс онлайнаар цуврал хэлбэрээр хүргэсэн цахим сургалтад тухай бүрт /Пүрэв гариг бүр/.
- JICA–ийн мэргэжлийн дагуух сургалтад давхацсан тоогоор 5 албан хаагчид,
- Нийслэлийн ЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвийн сэдэвчилсэн сургалтад нийт давхацсан тоогоор 24 албан хаагчид хамрагдсан.
- Салбар, чиглэлийн дагуу байгууллагуудын цахим сургалтад 8 албан хаагчид тус тус хамрагдсан бөгөөд давхацсан тоогоор 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 53 албан хаагчид сургалтад хамрагдсан болно.
- “Харилцан суралцах арга зүй” ижил түвшний байгууллага, албан хаагчид бие биенээсээ суралцаж, өөрсдийн чадавхаа бэхжүүлж, байнгын тасралтгүй хөгжих практик үр дүнд суурилсан сургалтад 3 албан хаагч хамрагдсан.
- Байгууллагын албан хаагчдаас худалдан авалт хийх АЗ-ын суурь мэдлэг олгох сургалтад 5 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. Мөн нэмээд 26 албан хаагчийг хамруулаад байна.






Алсын хараа-2050 сургалтын явц, сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байдал




Байгууллагын нийт 48 албан хаагчийн хувийн хэргийг шинэчилж, шинээр болон нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас шилжин ирсэн албан хаагчдад хувийн хэрэг үүсгэж, холбогдох баримтуудыг дараалын дагуу хавсарган хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан.



Албан хаагчдын хувийн хэргийг цэгцэлж, нөхөн бүрдүүлэлт хийсэн байдал

Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн №108 дугаартай мэдэгдлийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд байгууллагын нийт 68 албан хаагчдад Авлигын тухай хууль тогтоомж, ёс зүйн тухай сургалт зохион байгуулсан.







*Сургалтын сэдэв Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь*

Байгууллагын албан хаагчдын “Ээлжийн амралт эдлүүлэх хуваарь”-ийг Газрын даргын 2023 оны А/02 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд уг тушаалтай уялдуулан төрийн албыг тасралтгүй жигд явуулах зорилгоор албан хаагчдын “Орлон ажиллах хуваарь”-ийг хавсралтаар гарган, баталгаажуулсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар бүх ажилтан, албан хаагчид ээлжийн амралтаа биеэр эдэлсэн.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд:

1.“Цагаан сар” билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын 3 өндөр настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн дагуу газрын даргын 2023 оны А/17, Б/113 дугаар тушаалаар зардал гарган мөнгөн тэтгэмжийг олгосон.

2. Шинээр ам бүл нэмсэн 6 албан хаагчдадаа хөдөлмөрийн дотоод журмын дагуу мөнгөн тэтгэмж олгосон.

3. Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын 0-16 насны нийт 95 хүүхэд багачуудад “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсгийн дагуу газрын даргын гарын бэлгийг гардуулан өгсөн.

4. Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/511 дүгээр захирамжийн дагуу байгууллагын 8 төрийн жинхэнэ албан хаагчдад шинээр зэрэг дэв болон

нэмэгдлийг олгосон. Мөн ТҮ-ний нийт 27 албан хаагчид 2023 оны Б/144 дүгээр тушаалаар ур чадварын нэмэгдэл 20-25 хувиар олгосон.

5. МУ-ын ЗГ-аас Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан төрийн үйлчилгээний ажилтнуудын албан тушаалын үндсэн цалин хөлсийг төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалин хөлстэй дүйцүүлэх зорилгоор байгууллагын батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан тус газрын төрийн үйлчилгээний ажилтнуудын албан тушаалын үндсэн цалин хөлсийг 18 хувиар нэмэгдүүлэн газрын даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар шинэчлэн тогтоож, олгоод байна.

6. Мөн газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалаар байгууллагын батлагдсан цалингийн сандаа багтаан нийт ажилтан, албан хаагчдын унаа, хоолны мөнгийг өдрийн 9,500 төгрөг болгон нэмэгдүүлэн олгоод байна.

7. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалтад заасан дагуу 2 албан хаагчид тус бүр 300,000 төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламжийг олгосон.

8. Хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж буй БХХ-ийн Хяналт, зохицуулалтын ажилтнуудад хүйтний улиралд сар бүр витаминыг тогтмол өгч хэвшээд байна.

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус ажилтантай бөгөөд Авто тээврийн шалган нэвтрүүлэх 7 товчоонд 7 ш, Хяналт, зохицуулалтын 3 ажилтанд 3 ширхэг нийт 10 ширхэг хамгааллын хувцас, хэрэгслээр хангаж ажилласан.

10. Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг “Хөдөлмөрийн сахилга бат, ажлын хариуцлагыг сайжруулах жил” болгон зарласантай холбогдуулан газрын даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар байгууллагад дотооддоо авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн зохион байгуулалтаар баталгаажуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

11. Албан хаагчдын Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэж урамшуулж ажилласан. Мөн НБОАЖЯ, Нийслэлийн Засаг даргын, ИТХ-ын шагналд нийт 37, 2023 оны ажлын үр дүнгээр газрын даргын өргөмжлөлд 19 нийт 56 албан хаагчийг шагнаж урамшуулж ажилласан.

Монгол Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар манай байгууллагын чиг үүрэгт Төрийн хяналт, шалгалтын зарим чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нар шилжин ирсэнтэй холбогдуулан шилжин ирсэн улсын байцаагчийн ажиллах эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс нийслэлийн Засаг даргын 2023 оны А/164 дүгээр захирамжаар байгууллагын “Дүрмийг шинэчлэн” батлуулсан, мөн байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан шинэ чиг үүргийн албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авахаар Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ТАЗ-ийн 2023 оны 198, 199 дүгээр тогтоолуудаар шинэ бүтэц, орон тоондоо тохируулан

шинээр 5, шинэлэн 5 буюу нийт 10 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрлийг авч ажилласан.

**3.3 Албан бичиг шийдвэрлэлт:**

2023 оны жилийн эцсийн байдлаар Удирдлагад 3, Захиргааны хэлтэст 330 бичиг, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 363, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэст 181, Хяналт шалгалтын хэлтэст 79 нийт 956 албан бичиг ирсэн байна. Үүнээс хариугүй бичиг 762, хариутай бичиг 194 бичгийн шийдвэрлэлтийн хувь **99.87 хувь**, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн тоо **98,72 хувьтай** байна**.** Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад **1.69%**-өөр буурч бичгийн шийдвэрлэлтийн хугацаа багассан үзүүлэлттэй байна.

Мэргэжилтнүүдийн боловсруулан гаргаж байгаа баримт бичгийн стандартын дагуу үйлдэж холбогдох байгууллагуудад eDoc.ub.gov.mn программд оруулан явуулж байна. Хэвлэмэл хуудасны зарцуулалтад хяналт тавин хэвлэмэл хуудасны бүртгэлийн дэвтрийг хөтлөн ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар цаасаар 419, системээр бүртгэлд орсон 527, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс 10 албан бичиг хүлээн авч, бүртгэлийн дэвтэр хөтөлж eDoc.ub.gov.mn програмд скайнердаж оруулан удирдлагад шилжүүлэн ажилласан. Явсан бичгийг тухай бүрт нь бүртгэлийн дэвтэрт бүртгэн нэг хувийг тогтмол хадгалан ажиллаж байна. Албан хаагчдаас ирүүлсэн албан бичгийн болон тушаалын төслийг боловсруулан хэвлэмэл хуудсанд стандартын дагуу хэвлэж ажиллаж байна.

**Байгууллагын хэмжээнд баримт бичгийг хянан шийдвэрлэсэн тухай мэдээ, тайлан**

*Хүснэгт 20.* **/2023.01.01-2023.12.05/**

| Д/д | Нэгж/хэлтэс | Бүгд | Хариутай | Хариугүй | Хугацаа сунгасан | Шийдвэрлэлтийн дундаж хоног |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Удирдлага | 3 | - | 3 | - | - |
| 2 | Захиргаа, санхүүгийн хэлтэс | 330 | 97 | 233 | - | 3.68 |
| 3 | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 363 | 47 | 316 | 1 | 2.87 |
| 4 | Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс | 181 | 42 | 139 | - | 5.97 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Хяналт, шалгалтын хэлтэс | 79 | 8 | 71 | - | 5.90 |
| | **Нийт** | **956** | **194** | **762** | **1** | **3.98** |

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг өмнөх оны энэ үетэй харьцуулбал хугацаа хэтэрсэн албан бичгийн тоо 8-аар бага, албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 1.69 хувиар ихэссэн байна. Жилийн эцсийн байдлаар нийт 771 албан бичиг явуулсан ба өмнөх оны мөн үеэс 140-н албан бичгээр их, шийдвэрлэлтийн хувь 18.2% хувиар өссөн байна. Цаашид албан бичиг шийдвэрлэлтийн хугацаанд анхаарч зөрчлийн тоог багасгах талд анхааран ажиллана.

Жилийн эцсийн байдлаар зөрчлийн мэдээг хүснэгтээр харвал шийдвэрлэх хугацааны зөрчил 17 болтол багасаж, албан бичиг шийдвэрлэлтийн зөрчил 1, стандартын зөрчил 0 болсон байна. Цаашид зөрчлийн тоо үзүүлэлт багасгах тал дээр анхаарч нийт албан хаагч нарт стандартын болон баримт бичгийн шийдвэрлэлтэд анхааран, мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч ажилласан.

### 3.*3* Архив бүрдүүлэлт, хадгалалт ашиглалт:

Архивын нөхөн бүрдүүлэлтийн талаар: Төрийн байгууллага 8 жилд нэг удаа Архивын баримт нөхөн бүрдүүлэлтийн баримт хүлээлгэн өгөх журмын дагуу Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалтын дагуу Төрийн архивд нөхөн баяжилт хийх хугацаа болсон тул “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 13.9.5-д “Төрийн архивд баримт шилжүүлэхэд байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах баримтын жагсаалтыг төрийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын 04 дүгээр хурлаар данс, бүртгэл, жагсаалтыг хэлэлцүүлэн батлуулсан.

Дараах данс бүртгэлийг хүлээлгэн өгч устгах хэргийн жагсаалтын дагуу 326 баримтын ажлын хэсэг байгуулсан стандартын дагуу устгалд оруулсан байна. Үүнд:

*Хүснэгт-21*

| № | Төрөл | Д№ Б№ | Он цагийн хязгаар | ХН-ийн тоо | Тэмдэглэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Байнга хадгалах баримтын бүртгэл | 02 | 2013-2020 | 235 | Төрийн архивт 236 хадгаламжийн нэгжийг шилжүүлнэ |
| 2 | Захирамжлалын цахим баримтын бүртгэл | 01 | 2013-2020 | 1 DVD | |
| 3 | 70 жил хадгалах баримтын бүртгэл | 01 | 2013-2020 | 40 | Бүртгэлийг баталж, байгууллагын архивт хадгалах |
| 4 | Түр хадгалах баримтын бүртгэл | 01 | 2009-2020 | 1198 | |
| 5 | Устгах баримтын жагсаалт | 02 | 2009-2017 | 29 хэргийн 326 | Устгах баримтын жагсаалтыг батлах |
| | **Нийт** | | **2009-2020** | **1800** | |










### 3.4 Өргөдөл гомдлын талаар хийсэн ажил:

Байгууллагын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 362 өргөдөл, гомдол ирснээс, хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 339, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 3, судлагдаж байгаа 20 өргөдөл, гомдол байна. Удирдлагад 3, Захиргаа, санхүүгийн хэлтэст 115, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 107, Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэст 93, Хяналт шалгалтын хэлтэст 44 өргөдөл, гомдол байна.

Өргөдлийн дамжин ирсэн эх үүсвэрүүд НҮНТ-д бүртгэсэн 39, ННЗБ 132, 1800-1200 дугаараас ирсэн 27, 11-11 төвөөс ирсэн 155, гар утасны апп-ээр ирсэн 4, eservice 5 нийт 167 өргөдөл, гомдол ирсэн байна.

Мөн байгууллагад цаасаар ирсэн өргөдөл, гомдлыг скайнердаж erp.ulaanbaatar.mn-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.

Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл

- 5 хоногт багтаан шийдвэрлэсэн 186
- 10 хоногт багтаан шийдвэрлэсэн 75
- 15 хоногт багтаан шийдвэрлэсэн 56
- 30 хоногт багтаан шийдвэрлэсэн 42
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 3 өргөдөл байна.

2023 оны жилийн эцсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 20 цаг 9 минут байна.

Иймээс цаашид өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хоногийг бууруулах мөн шийдвэрлэлтийн байдлыг хамгийн багадаа 5-аас дээш үгээр оновчтой шийдвэрлэх тал дээр анхаарч ажиллаж байна.




Байгууллагын 7 хоног тутамд шуурхай хуралд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн мэргэжилтнүүд тухай бүр нь арга хэмжээ авч анхааруулан дахин алдаа гаргахгүй байхыг анхааруулан ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг багасгаж нийслэлээс тавьж байгаа нэг оронтой тоонд хүрсэн амжилтаа бататган ажиллаж, төлөвлөгөөний дагуу зөрчил дутагдлыг багасгахаар төлөвлөн ажиллаж байна.

Өргөдөл гомдлыг сайжруулах төлөвлөгөөнд дундаж хугацаа үзүүлэлтийг багасгах, өргөдөл гомдлыг хууль эрх зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хуулийн хугацаанд иргэнд танилцуулан албан бичгээр хариу өгч ажилласан. ERP өргөдөл гомдлын системд тогтмол хяналт тавьж, ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь удирдлагад шилжүүлж байна.

### *3.5* Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 2023 оны тээврийн сонгон шалгаруулалтыг цахим сайтад байршуулахад хяналт тавин ажиллаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан нийт тээврийн 31 компани тээврийн үйл ажиллагаа явуулж байна.

Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, агуулахын 2023 оны сонгон шалгаруулалтыг цахим сайтад байршуулан нийт 12 агуулах сонгон шалгаруулсан.

Мөн байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх болон Улаанбаатар хотын агаар дахь микро элементийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлуудыг зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хяналт тавин ажилласан.

Хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгийг олон нийтэд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, хариуцлагатай, шуурхай байдлаар хэрэгжүүлэхэд хяналт тавин ажилласан.

***3.6.*** **Төсөв санхүү, орлого бүрдүүлэлтийн чиглэлээр:**

2023 оны батлагдсан төсвийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 31-ний байдлаар нийт 25,334,193,900 төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, нийт 24,898,485,870 төгрөгний зарлагын гүйлгээг холбогдох хууль тогтоомжид зааснаар зориулалтын дагуу захиран зарцуулсан.

Төсвийн тухай хуульд заасны дагуу сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэн тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн холбогдох албан тушаалтнаар баталгаажуулан ажилласан.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

### 4.1. Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгох ажлын хүрээнд:

Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, байгууллагын албан ёсны http://aprd.ub.gov.mn/ цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан.

Агаарын бохирдол хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах зөвлөмж, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх 18 шторк, зөвлөмж сэрэмжлүүлэг бүхий 42 цуврал постер, 35 мэдээ мэдээллийг байгууллагын Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар фэйсбүүкийн цахим хуудас, албан ёсны https://aprd.ub.gov.mn/ вэбсайт, хамтран ажилладаг 16 сайт, 6 телевизээр дамжуулан давхардсан тоогоор 350.000 гаруй хүнд хүргэж ажилласан.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу https://aprd.ub.gov.mn/ вэбсайтын 6 үндсэн цэсний 10 дэд цэсийн мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан.










*Зөвлөмж, мэдээлэл хүргэж байгаа нь*

Тайлант хугацаанд байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажлын талаар NTV телевизийн “Өөр өнцөг” хэлэлцүүлэг АЧХЗБХ-ийн дарга Г.Даваажаргал, UBS телевизийн “Зочны цаг”-т угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргэж АЧХЗБХ-ийн дарга Г.Даваажаргал, “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнд нэгдэж иргэд, олон нийтийг уриалж, ХШХ-ийн ахлах мэргэжилтэн /Улсын ахлах байцаагч/ Б.Угтахбаяр нарыг оролцуулж мэдээлэл өгсөн.







*Нэвтрүүлэгт ярилцлага, мэдээлэл хүргэсэн нь*

Зөв мэдээ ХМБ, Монголын сэтгүүлийн холбоо, Эксперт компаниудтай хамтарч ажиллах гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн акт, проткол, тайланг албан бичигт оруулж хүлээж авсан.



78 Материал нийтлэгдсэн огноо: 2023-03-15 15:51:19 Мэдээний линк: https://vip76.mn/content/89156

Эх сурвалжууд: Vip76.mn Уншсан тоо: 1704

**“Угаарын хийн эрсдэлээс сэргийлье” сургалт зохион байгуулагдлаа**

Цаг агаар дулаарч байгаатаа холбоотой гэр байшингийн гадна дотно агаарын температурын зөрүү багасаж яндангийн татлат муудсанаас айл өрхүүд угаарын эрсдэлд өртөх, эрүүл мэнд амь насаараа хохирох эрсдэл үүсдэг билээ.

Цаг агаар дулаарч байгаатаа холбоотой гэр байшингийн гадна дотно агаарын температурын зөрүү багасаж яндангийн татлат муудсанаас айл өрхүүд угаарын эрсдэлд өртөх, эрүүл мэнд амь насаараа хохирох эрсдэл үүсдэг билээ.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын ХШХ-ийн дарга Б.Угтахбаяр



90 Материал нийтлэгдсэн огноо: 2023-02-15 09:50:12 Мэдээний линк: https://vip76.mn/content/88666

Эх сурвалжууд: Vip76.mn Уншсан тоо: 1974

**ФОТО: Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлье!**

Хавар, намрын улиралд гэр байшингийн гадаад, дотоод орчны температурын зөрүү багасч яндангийн таталт муудан угаарын хийн эрсдэл үүсэх нөхцөл бүрддэг. Иймд иргэд та бүхэн мэргэжлийн байгууллагийн зөвлөмжийг хэрэгжүүлж:



Хавар, намрын улиралд гэр байшингийн гадаад, дотоод орчны температурын зөрүү багасч яндангийн таталт муудан угаарын хийн эрсдэл үүсэх нөхцөл бүрддэг. Иймд иргэд та бүхэн мэргэжлийн байгууллагийн зөвлөмжийг хэрэгжүүлж:

- Яндангаа хөөлөх
- Гэр, байшингаа дулаалах
- Угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, зайг солих
- Яндангийн сойлтыг хаахгүй байх
- Пийшин, зуухныхаа бүрэн байдлыг хангаж хайртай дотны хүмүүсээ угаарын хийн эрсдэлээс сэргийлээрэй.

**Угаарын хийн эрсдэлээс сэргийлж, иргэн бүр анхаарал болгоомжтой байж, энхрий бяцхан үрсээ харгалзах хүнгүйгээр үлдээхгүй байхыг уриалж байна!**

**Угаарын хий мэдрэгчийг хэрхэн ашиглах вэ?**

**4.3 Хууль, эрх зүйн чиглэлээр:**

Байгууллагын үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах ажлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

• Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой нийт 116 тушаалд хууль, эрх зүйн талаас нь санал, зөвлөгөөг өгсөн.

• Хүний нөөц, боловсон хүчинтэй холбоотой нийт 154 тушаалын төслийг боловсруулж, хэлтсийн дарга нараар хянуулан, саналын хуудсаар санал авч, газрын даргаар батлуулан ажилласан.

• Захиргааны хэлтсээс боловсруулагдан гарсан нийт 10 гэрээ;

• Бодлогын хэрэгжилтийн хэлтсээс боловсруулагдан гарсан нийт 103 гэрээ;

• Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсээс боловсруулагдан гарсан нийт 70 гэрээнд хууль эрх зүйн талаас нь танилцаж санал, зөвлөгөөг өгч ажилласан.

Нийслэлийн МХГ татан буугдсан холбоотойгоор байгууллагын үндсэн чиг үүрэгт Төрийн хяналт шалгалтын зарим чиг үүргийг тусгуулахаар нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан, нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/164 дүгээр захирамжаар газрын “Дүрмийг шинэчлэн” батлуулсан.

Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэгт Төрийн хяналт шалгалтын зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсантай холбоотойгоор байгаль орчны хяналтын улсын байцаагч нарын зөрчлийн хэргийг бүртгэлжүүлэн нийслэлийн Прокурорын газарт niislelprozurchil@gmail.com цахим хаягт тухай бүрт хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 19 зөрчлийн хэргийг бүртгэн ажилласан байна.

Хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах эрх бүхий 26 албан тушаалтнуудаас 2022 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг тайлант хугацаанд хүлээн авсан бол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1649 дүгээр захирамжаар нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчид шилжин ирсэнтэй холбогдуулан байгаль орчны хяналтын 6 байцаагчдаас ХАСХОМ-ийг 2023 оны 01 дугаар сарын 23-ны өдөр баталгаажуулан авч холбогдох газарт нь хүргүүлэн ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар ХАСХОМ 17, ХАСУМ 14 тус тус хянуулж ажилласан.

### ***4.4. Санхүүгийн ил тод байдал:***

Shilendans.gov.mn сайтад сар бүр болон тухай бүр оруулах мэдээлэлд Байгууллагын бүтэц, орон тоотой холбоотой тушаал болон хөрөнгө, зардал гаргах тушаал шийдвэрүүдийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим санд оруулж ажилласан. Тайлант хугацаанд:

- Бүтэц, орон тоо, албан хаагчдын цалинтай холбоотой А тушаал болон хөрөнгө, зардал гаргах тухай А тушаал байршуулж, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

### ***4.5. Хүний нөөцийн ил тод байдал:***

*Хүснэгт-22*

| № | Үйл ажиллагаа | Гүйцэтгэл | Гүцэтгэл ийн хувь |
|---|---|---|---|
| 1. | 2. | 3. | 4. |
| 1 | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журмыг баримтлан өөрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулах замаар нөхөн томилгоог хийж байгаа бөгөөд тайлант хугацаанд 5 сул орон тоо гарсныг бүрдүүлсэн болно. Сул орон тооны мэдээллийг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны 1/643 дугаар албан бичгээр Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан дагуу хуулийн хугацаанд нь Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд албан бичгээр мэдээлэн ажилласан. | 100% |
| 2 | Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан, Төрийн албаны зөвлөлөөр | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар манай байгууллагын чиг үүрэгт | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | батлуулах; | Төрийн хяналт, шалгалтын зарим чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нар шилжин ирсэнтэй холбогдуулан шилжин ирсэн улсын байцаагчийн ажиллах эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс нийслэлийн Засаг даргын 2023 оны А/164 дүгээр захирамжаар байгууллагын "Дүрмийг шинэчлэн" батлуулсан, мөн байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан шинэ чиг үүргийн албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авахаар Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ТАЗ-ийн 2023 оны 198, 199 дүгээр тогтоолуудаар шинэ бүтэц, орон тоондоо тохируулан шинээр 5, шинэлэн 5 буюу нийт 10 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрлийг авч батлан ажилласан. (csc.gov.mn) болон (www.aprd.ub.gov.mn) сул орон тоог нийтэд мэдээлэн, сонгон шалгаруулалтыг зарлуулсан. | |
| 3 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудаснаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Байгууллагын танилцуулга, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Газрын даргын тушаал, албан тушаалын тодорхойлолт зэргийг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн салбарт байршуулан тухай бүр мэдээлж ажилласан. | 100% |
| 4 | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын Ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, ёс зүйн дэд хорооны дүрмийг баталж, байгууллагын нийт албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалт зохион байгуулж, сургалтын зардалд 2.2 сая төгрөг зарцуулсан.<br>Мөн ажлын байранд бүх нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг нийт албан хаагчдад танилцуулан, гарын үсэг зуруулж, холбогдох дүрэм журмыг мэдээллийн самбарт байршуулсан. (http://new.aprd.ub.mn/c/11/13) | 100% |
| 5 | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар цахим хуудсанд ойлгомжтой байдлаар мэдээлэх | Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх Засгийн газрын журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын албан хаагчдын Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийг газрын даргын тушаалаар батлан ажилласан.<br>Үнэлгээний баг нь ажилтан, албан хаагчдад журам болон үнэлгээний талаарх арга зүйг тогтмол өгч байгууллагын дотоод сүлжээгээр танилцуулан ажиллаж байна. | 100% |
| **Хэрэгжилтийн дундаж хувь: 100** | | | |

## ТАВДУГААР БҮЛЭГ ДОТООД БОЛОН БУСАД НЭМЭЛТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ.

### 5.1 Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо, шаардлага MNS ISO 9001:2016 байгууллагад хэвшүүлэх, сайжруулалт хийх, хяналт тавих ажлын талаар

Газрын даргын 2023 оны А/41 дүгээр тушаалаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйл, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Тус ажлын хэсэг газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан "Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх хамрах хүрээ, ажлын төлөвлөгөөний 18 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд боловсруулсан байгууллагын үндсэн үйл ажиллагааны чанарын менежментийн тогтолцооны үйл явц, түүний зураглалыг дэлгэрэнгүй болгох талаар "Менежмент ба ур чадварын хүрээлэн"-ийн зөвлөхүүд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн дагуу үндсэн үйл ажиллагааны чанарын менежментийн тогтолцооны үйл явц, түүний зураглалд сайжруулалт хийсэн.




Газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар

 

*ISO чанарын менежментийн тогтолцоо сургалт*

Тус ажлын хэсэг газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугааар тушаалаар батлагдсан “Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх хамрах хүрээ, ажлын төлөвлөгөөний 18 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд зөвлөх Аудитор Б.Мөнхдаваагийн удирдлаганд байгууллагын ISO9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан 11 удаагийн чиглүүлэх сургалтад хамрагдан мэдээлэл арга зүйгээр хангагдан ажилласан.

**Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай**

**5.2 Байгууллагын албан хаагчдын талаарх сэтгэл ханамжийн судалгааг** 2023 онд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд хамт олныхоо дунд хандлага, ёс зүй, багаар ажиллах, харилцааны ур чадвараараа манлайлан ажилласан ажилтан, албан хаагчийг үнэлэх судалгааг нийт албан хаагдаас авсан.










**5.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэх ажлын хүрээнд;**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан. 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын ажилтан, албан хаагчид БГД, 20 дугаар хороо, ТЭЦ-4-ийн урд байрлах “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”, 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Ар гүнт, Инчеон цэцэрлэгт хүрээлэн”, 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тус тус 300 модны суулгац, 09 дүгээр сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Баруун салааны Бумбатын рашааны орчимд 78 ширхэг мод бут, суулгацыг тарьсан.

Мөн “БИДНИЙ ОРОЛЦОО-ЦЭВЭР ОРЧИН” аяны хүрээнд тус газрын эцэг эхийн зөвлөл, Захиргаа, санхүүгийн хэлтсээс санаачлан албан хаагчдынхаа хүүхдүүдэд экологийн боловсрол олгох, амралтын өдрийг гэр бүлээрээ үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2023 оны 05 дугаар сарын 28-ны өдөр мод тарьсан бөгөөд энэхүү арга хэмжээнд 30 гаруй албан хаагчдын 80 гаруй хүүхэд багачууд идэвхтэй хамтрагдаж мод тарьж, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн инженер техникийн ажилтнууд хүүхэд, багачуудад арга зүй зөвлөмж мэдээллийг өгч, хамтран ажилласан.




Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд албан хаагчдын хүүхэд, багачуудаар мод тариулж буй байдал










**5.4 Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний талаар**

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын Дотоод хяналтын ажлын хэсгийн 2023 оны төлөвлөгөөний 1-р улиралд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын байранд гүйцэтгэх ажлын гүйцэтгэл, сайжруулсан шахмал түлш нөөцлөх агуулахын стандарт, түлшний нөөцлөлт, түлш борлуулах цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих” Удирдамжийн дагуу батлагдсан хуваариар 2023 оны 2 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Хяналтын зохицуулалтын ажилтнуудын ажлын байрны цаг ашиглалт, ажил гүйцэтгэл болон ёс зүй, зан харилцаа мөн сайжруулсан шахмал түлш хадгалах, нөөцлөх Хангамжийн бааз, агуулахууд, түлш борлуулах цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажиллалаа. Хяналт шалгалтаар нийт 25 агуулах, 600 гаруй борлуулалтын цэгүүд хамрагдсан бөгөөд түлш нөөцлөлт хадгалалт хэвийн 38000 тонн, борлуулалтын цэгүүдэд гомдол саналгүй өдөрт 10 тоннын борлуулалттай үйл ажиллагаа хэвийн ажиллаж байна.

Дотоод хяналтын ажлын хэсгийн 2023 оны төлөвлөгөөний 2-р улиралд хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын даргаар Удирдамж батлуулан, байгууллагын лабораторийн үйл ажиллагаа, суурин харуулуудын хэвийн ажиллагаа стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллалаа. Хяналтаар гарсан зөрчилгүй харуулын байрны цэвэрлэгээ, хяналтын самбарын цахилгааны хамгаалалт зэрэгт анхаарах заавар зөвлөмж өгсөн.









**ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Агаарын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих

Агаар бохирдуулагч бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн тооллогыг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбартай хамтран нутаг дэвсгэртээ зохион байгуулж тархалтын загварчлал гаргах

Байгууллагын цаасан суурьт архивын бичиг баримт хадгалах нягтруулсан шүүгээг суурилуулах

Цаашид албан бичиг шийдвэрлэлтийн хугацаанд анхаарч зөрчлийн тоог багасгах талд анхааран ажиллах

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАТШАГАЙ

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:МЭРГЭЖИЛТЭН Ц.БААСАНХҮҮ